| 4.15 | Газрын архивын ажлыг холбогдох хууль, тогтоомж, стандарт, заавар журмын хүрээнд хангуулан ажиллаж, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” боловсруулан батлуулж Баримт бичиг, материалуудыг ХХНЖ-ын жагсаалтын дагуу жил бүрийн 1 улиралд багтаан хэлтсүүдээс хүлээн авах, архивд нөхөн бүрдүүлэлт хийх | - | Хүлээн авсан баримтын тоо, хувь | - | 100% | Газрын архивын үйл ажиллагааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” болон газрын даргын баталсан 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/83 дугаар тушаал “Архивын дүрэм” бусад холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт болон салбарын жагсаалт”-ыг удирдлага болгон газрын 2026 онд хөтлөгдөх “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын төсөл боловсруулж, хэлтсүүдээс санал авч нэгтгэн, 2026 оны 05 дугаар сарын 02-ны өдөр газрын дэргэдэх БНШК-ын 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн, 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдөр газрын даргаар батлуулав.<br>Газрын даргын баталсан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”, 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Архивд баримт хүлээн авах дотоод хуваарь”-ийн дагуу газрын архивд дараах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтуудыг бүрдэл бүрэн хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийв. Үүнд:<br>✓ Байнга хадгалах 600 хн,<br>✓ Түр хадгалах 344 хн,<br>✓ 70 жил хадгалах 6 хн,<br>✓ Тусгай төрөл 11 хн, нийт 961 хадгаламжийн нэгжийг газрын архивд бүрэн бүрдэлтэй хүлээн авсан.<br>Газрын архивд нөхөн бүрдүүлсэн 961 цаасан суурьт хадгаламжийн нэгжээс 676 хадгаламжийн нэгжийг цахим (PDF файл) хэлбэрээр хүлээн авсан. Үүнд:<br>✓ Удирдлагын байнга хадгалах 59 хн,<br>✓ Тендер гүйцэтгэлийн байнга хадгалах 461 хн,<br>✓ Гэрэл зургийн байнга хадгалах 1 dvd,<br>✓ Захирамжлалын цахим баримтын бүртгэл 1 dvd,<br>✓ Архивын байнга хадгалах 9 хн<br>✓ 70 жил хадгалах 4 хн,<br>✓ Түр хадгалах 130 хн<br>✓ Тусгай төрөл 11 хн | |
| 4.16 | Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 93,8% | 100% | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Журам батлах тухай" А/188 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны "Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам"-ыг хяналтад авч, газрын нийт удирдлагуудад танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж, газрын даргад танилцуулан, тухай бүр нь тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлсэн. | 100 хувь |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>(Шуурхай хурал 2025, 2026 оны хагас жилийн байдлаар)<br><table><tr><th>Он</th><th>Хурал (удаа)</th><th>Үүрэг даалгавар (удаа)</th><th>Биелэлт (хувь)</th></tr><tr><td>2025</td><td>10</td><td>27</td><td>98</td></tr><tr><td>2026</td><td>10</td><td>28</td><td>98,2</td></tr></table>Мөн Нийслэлийн Удирдах ажилтнуудын 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт 2026 оны 05 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд хийсэн уулзалтаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ERP системээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт, Газрын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал болон шийдвэрлэх арга замын саналыг нэгтгэн, 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, хөгжлийн бодлогын хэлтэст ERP системээр хүргүүлэв.</td><td></td></tr>
<tr><td>4.17</td><td>Газрын үйл ажиллагааны тайланг (улирал, жилийн эцэс) гарган холбогдох дээд байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх</td><td>-</td><td>Тоо, хувь</td><td>100%</td><td>100%</td><td>Газрын үйл ажиллагааны 14 хоногийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, сар бүрийн 2, 4 дэх долоо хоногт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт албан бичгээр нийт 8 удаа ((2026.01.21-ний 01/285, 2026.02.04-ний 01/593, 2026.02.16-ны 01/804, 2026.03.10-ны 01/1110, 2026.04.14-ний 01/1750, 2026.04.28-ны 01/2051, 2026.05.12-ны 01/2293, 2026.05.25-ны өдрийн 04/2569) хүргүүлэв.</td><td>100 хувь</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Газрын үйл ажиллагааны 1 дүгээр улиралд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1558 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв. Хагас жилийн тайланг нэгтгэж, 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| 4.18 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих | - | Тоо, хувь | 100% | 100% | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны “Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх тухай 58 дугаар зарлиг, 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 44 дүгээр зарлиг, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчийн баталсан 2026 оны хаврын "Мод тарих арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж, “Байгальд өгсөн бүхэн буцаж ирдэг” уриан дор 2026 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Налайх дүүргийн "Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн"-д нийт 20 ширхэг Миндаль модыг, 11 албан хаагч тарьж усалгаа хийв. Мод тарьсан тухай мэдээллийг бэлтгэн, 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Газрын цахим сүлжээ https://invest.ub.gov.mn/ болон ERP системд байршуулав. | 100 хувь |
| 4.19 | Газрын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн биелэлт (улирал бүр)-ийг хангаж ажиллах | - | Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь | 98% | 100% | Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/49 дүгээр тушаалаар 2025-2028 онд хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг болох “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2026 оны төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр газрын даргаар батлуулан, 1 дүгээр улирлын биелэлтийг 92.8 хувьтай газар, хэлтсийн даргад тус тус тайлагнан https://invest.ub.gov.mn/ сайтад байршуулав. | 96.9 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус хөтөлбөрийн хагас жилийн биелэлт 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 96.9 хувь, 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нэгтгэн, газрын даргад танилцуулахаар ажиллаж байна. | |
| 4.20 | Газрын хэмжээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг тодорхой үе шаттайгаар оновчтой хэрэгжүүлж буй эсэхэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хэрэгжүүлж, заавар зөвлөгөө өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд газрын хэмжээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг Барилгын тухай хууль, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 278 дугаар тогтоол болон бусад холбогдох дүрэм журмыг хангуулан нийт 191 гүйцэтгэлээс 69 гүйцэтгэлийн зөрчлийг арилгуулан баталгаажуулж, бүртгэл хийв.<br>Газрын хэмжээнд хэрэгжиж буй барилга угсралт, инженерийн шугам сүлжээ, цахилгаан хангамж, тохижилт, ногоон байгууламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хяналт шалгалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 95 хувь |
| 4.21 | Барилга угсралтын ажлын болон зөвлөх үйлчилгээний гэрээ, зохиогчийн хяналтын гэрээний бүрдлийг хянах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хэрэгжилтийн явцад үүссэн зөрчлийг илрүүлэх, илрүүлсэн зөрчлийг арилгуулах | - | Тоо, хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд нийт 554 гэрээг чиг үүргийн хүрээнд хянан баталгаажуулж, бүртгэл хөтлөв. Хянан баталгаажуулсан гэрээг ангилбал:<br>✓ Барилга угсралтын ажлын гэрээ 141,<br>✓ Зохиогчийн хяналт хийх гэрээ 70,<br>✓ Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ 18,<br>✓ Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээ 5<br>✓ Барилга угсралтын ажлын гэрээ сунгалт 245,<br>✓ Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ сунгалт 31,<br>✓ Нэмэлт гэрээ 2,<br>✓ Гэрээ цуцлах 5,<br>✓ Бусад 3,<br>✓ Бараа, тоног төхөөрөмж худалдан авах 34 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт хянан баталгаажуулсан гэрээнээс 174 гэрээний зөрчлийг арилгуулан бүрдэлийг хангуулж ажиллав. | |
| 4.22 | Тухайн жил Нийслэлд төсвийн хөрөнгө оруулалтаар болон бусад эх үүсвэрээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах | - | Хуулийн хэрэгжилт, хувь | 100% | 100% | Нийслэлийн хэмжээнд 2026 онд Улсын төсөв, Нийслэлийн төсөв, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн хөрөнгөөр хэрэгжих 1,584.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1114 ажлын мэдээллийн санг үүсгэж 30 үзүүлэлтээр 7 хоног бүр тогтмол явцын мэдээллээр 23 удаа шинэчлэв.<br>2026 онд шинээр хэрэгжиж буй 291 хөрөнгө оруулалтын ажлуудын байршлуудыг google earth программд холбов.<br>2025-2026 онд он дамжин манай газраар хэрэгжих барилга угсралт, их засвар, зураг төсвийн 1,664.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 435 ажлын мэдээллийг загвар хүснэгтийн дагуу бэлтгэж, явцын мэдээллийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын барилга угсралт, их засвар, зураг төсвийн мэдээгээр 30 үзүүлэлтээр 7 хоног бүр тайлант хугацаанд нийт 23 удаа шинэчлэв.<br>2026 онд газарт эрх шилжин захиалагчийн хяналт тавьж хэрэгжүүлэх 228 ажлын захирамж гарснаас Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 164 ажлын зөвлөмж ирж, гэрээ байгуулагдсан байна.<br>Нийслэлийн хэмжээнд Улс, нийслэл, дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 920 төсөл арга хэмжээ тендер зарлагдахаас тайлант хугацааны байдлаар 801 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж 87 хувийн дундаж үзүүлэлттэй байна. 2026 онд шинээр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын Худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг 7 хоног бүр 23 удаа шинэчилсэн. | 100 хувь |
| 4.23 | Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2026 онд | - | Тоо, хувь | - | 100% | Улсын төсвийн хөрөнгөөр манай газарт 2026 онд Боловсролын салбарт хэрэгжиж буй | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжих Боловсролын салбарын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээг тогтмол гаргах, хүргүүлэх | | | | | хөрөнгө оруулалтын 25 ажлын мэдээлэл бэлтгэж Боловсролын яаманд цахимаар 2026 оны 02 дугаар сарын 04-ний хүргүүлэв.<br>2026 онд Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар боловсролын салбарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний мэдээг загвар хүснэгтийн дагуу боловсруулан, 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар Нийслэлийн Боловсролын газарт 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахимаар (ERP) хүргүүлэв.<br>Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын салбарт 617.9 тэрбум төгрөгний гэрээний үнийн дүнтэй 141 барилга угсралт, их засварын ажил 54 хувийн дундаж гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. 2026 оны хагас жилийн боловсролын салбарын мэдээллийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.<br>2026 онд хэрэгжиж байгаа сургууль, цэцэрлэг, бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгыг ашиглалтад орсон болон орох гэж ангилан гаргаж, газрын даргад 2 удаа танилцуулсан. Мөн 2026 онд боловсролын салбарт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийн нэгдсэн хүснэгтийг 7 хоног тутам гаргаж, газрын удирдлагуудад танилцуулав. | |
| 4.24 | Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 дүгээр захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлж, үзүүлэлтийн үр дүнг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Захирамжийн хэрэгжилтийг хангах Хотын хөгжлийн индексийн үр дүнг сайжруулах чиглэлээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын удирдлагатай 2026 онд байгуулсан "Хариуцлагын гэрээ"-нд тусган ажиллаж, Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг тооцох үйл ажиллагааны төлөвлөгөөнд манай газрын чиг үүрэгт хамаарах 2026 онд хэрэгжиж байгаа нийт 423 төсөл, арга хэмжээний мэдээллийг загвар хүснэгтийн дагуу боловсруулан, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 1 дүгээр улирлын | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийн хүрсэн үр дүнг жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцож тайлагнах, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх | | | | | байдлаар Нийслэлийн Статистикийн газарт цахимаар (ERP) хүргүүлэв.<br>2026 оны хагас жилийн байдлаар хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна. | |
| 4.25 | Газрын шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулах | - | Журмын хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газрын дотоод үйл ажиллагаатай холбогдуулан шинэчлэх шаардлагатай журмын төсөл боловсруулан дараах дүрэм, журмыг шинэчлэн газрын даргаар батлуулав. Үүнд:<br>1.Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Тушаал хүчингүй болгож, Газрын тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас хариуцан ажиллах тухай” А/12,<br>2.“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх журам”-ыг Газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/15,<br>3.Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Тушаал хүчингүй болгож, Ёс зүйн дүрэм шинэчлэн батлах тухай” А/45,<br>4.Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Тушаал хүчингүй болгож, Даргын зөвлөлийн ажиллах журам шинэчлэн батлах тухай” А/47,<br>5.Газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Тушаал хүчингүй болгож, газрын шуурхай хурал зохион байгуулах журам, бүрэлдэхүүн, загвар хуснэгт шинэчлэн батлах тухай” А/50 дугаар тушаал. | 100 хувь |
| 4.26 | Хамт олны дунд эерэг хандлага, хамтач соёлыг төлөвшүүлэх, хэлтэс хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хувь | - | 100% | Газрын алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчдын дунд нийт 5 төрөлт спорт тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 260 албан хаагч хамрагдсан.Үүнд:<br>✓ 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр "Гар бөмбөг", "Ширээний теннис”-ний | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аварга шалгаруулах тэмцээнд 5 багийн нийт 90 тамирчин,<br>✓ 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр "Боулинг"-ийн аварга шалгаруулах тэмцээнд 5 багын нийт 88 тамирчин,<br>✓ 2026 оны 03 дугаар сарын 21-ны өдөр "Сагсан бөмбөг", "Дартс"-ын аварга шалгаруулах тэмцээнд 5 багийн 82 тамирчин оролцов.<br>Мөн Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Спорт наадам" арга хэмжээнд манай газраас Сагсан бөмбөгийн 1 баг, Гар бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 баг буюу нийт 18 тамирчин амжилттай оролцсон.<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/396 дугаар захирамжийн хүрээнд "Улаанбаатар марафон 2026" Олон улсын гүйлтийн тэмцээн 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж, манай газраас 5 км-т 9, 10 км-т-11, 21 км-т 7, нийт 27 албан хаагч амжилттай оролцов.<br>Хагас жилийн байдлаар нийт нийт 7 төрлийн спортын тэмцээн уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 305 албан хаагч хамрагдав. | |
| 4.27 | Хамт олны сэтгэл ханамжийн судалгаа хийх, үр дүнг тайлагнаж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх | | Судалгааны үр дүнгийн хэрэгжилт, хувь | - | 100% | Тайлант хугацаанд хамт олны сэтгэл ханамжийн судалгааг ажлын байрны орчин, албан хаагчдад үзүүлж байгаа нийгмийн баталгаа, сургалт, дэмжлэг, тусламж, байгууллагын соёлын төлөвшил чиглэлээр холбогдох асуумжийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 22-ны өдрүүдэд судалгаа авч, судалгааны үр дүнг газрын даргад танилцуулав.<br>Судалгааны дүгнэлтээс цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.28 | Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг үе шаттай төлөвлөн ажиллах, тайлагнах | | Хамрагдсан албан хаагчийн тоо 51,55% | 95 хувь | 100% | Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дэмжих, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлуулан, дараах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1.Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг олгох чиглэлээр эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж боловсруулж, газрын дотоод сүлжээнд 5 удаа байршуулан мэдээллээр хангаж ажиллав.Үүнд:<br>✓ Эрүүл зөв хооллох зөвлөмж<br>✓ Өглөөний цайны ач тус<br>✓ Хаврын ядаргаа<br>✓ Халдвараас хэрхэн сэргийлэх вэ?<br>✓ Өдөр тутмын эрүүл зуршил.<br>2."Улаанбаатар марафон 2026" олон улсын гүйлтэд манай газраас 5 км-т 9 ,10км-т 11, 21км-т 7, нийт 27 албан хаагч амжилттай оролцов.<br>3.Газрын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дэмжих хүрээнд "Health education academy"-тай хамтран "Стрессийн менежмент" сэдэвт сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, 51 албан хаагч хамрагдав. | 100 хувь |
| 4.29 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, тайланг холбогдох газарт хүргүүлэх | - | Хуулийн хэрэгжилт, хувь | 93,5% | 100% | Газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г 4 зорилт 7 арга хэмжээний хүрээнд батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газарт хүргүүлэхээр мэдээллийг нэгтгэж байна. | 100 хувь |
| Хуулиар олгосон чиг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | **99.3 хувь** |
| Зорилт 5.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсуулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах эхлүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөний засаглалын шинэчлэлийн зорилго, хүлээгдэж буй үр дүн, тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийцүүлэн "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны "Журам батлах тухай" А/555 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэх журам"-ын дагуу 2026 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор жилд 1 удаа тайлагнаж ажиллана. | 100 хувь |
| 5.2 | Албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн https://erp.ulaanbaatar.mn/ цахим системийг газрын үйл ажиллагаанд ашиглах | - | Шийдвэрлэлтийн хувь | - | 100% | Албан хэрэг хөтлөлтийн Edoc системээр 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 2020 албан бичиг ирсэн бөгөөд хариутай 519 хариугүй 1501 байна. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн албан бичиг 3 албан бичгийн шийдвэрлэлт 99,7 хувьтай байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 6,4 байна. Газраас нийт 2664 албан бичиг иргэн, Аж АН, байгууллага руу илгээн ажиллаж байгаагаас хариутай албан бичиг 1302, хариугүй албан бичиг 1362 байна.<br>Явуулж байгаа албан бичгийг баримт боловсруулалт цэсд оруулан тоон гарын үсгийн төхөөрөмжөөр баталгаажуулан программд хадгалж erp.ulaanbaatar.mn цахим системийг газрын үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>Албан бичгийн үлдэх хувийг цаасан хэлбэрээр Архивын нэгж болгон хадгалж байна. | 97.7 хувь |
| 5.3 | Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг баримтлан шийдвэрлэлтийн тайланг | - | Шийдвэрлэлтийн хувь | 97% | 100% | 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Erp.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын системд нийт 67 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнээс: иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 63, албан хаагчаас 4 өргөдөл, гомдол бүртгэгдсэн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлэх | | | | | ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 49 буюу 73 хувь, судлагдаж байгаа 18 буюу 26 хувь, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 12 цаг 34 минут байна.<br>Тайлант хугацаанд нийт 67 өргөдөл гомдлыг дараах байдлаар хяналт тавин ажиллав.<br>✓ Өдөрт нь багтаан хүлээн авахыг сануулсан -67 удаа<br>✓ Өдөрт нь багтаан шилжүүлэхийг сануулсан-67 удаа<br>✓ Явцын тэмдэглэл хөтлөхийг сануулсан-74 удаа<br>✓ Буцаалт 3 хоногт хийхийг сануулсан-5 удаа<br>✓ Холбогдох файл хавсарган шийдвэрлэхийг сануулсан-70 удаа нийт давхардсан тоогоор 283 удаа утсаар болон биечлэн сануулан бүртгэл хөтлөн ажиллав.<br>Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын дагуу 2026 оны 1 дүгээр улирлын тайлан мэдээг Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн албажуулж 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/1425 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.<br>Тус журмын 5.4.2 дах заалтын дагуу хагас жилийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 30-ны дотор хүргүүлэхээр нэгтгэж байна. | |
| 5.4 | Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр | - | Зөрчлийн тоо, хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд хороодын хэсгийн ахлагч нарын системээр дамжуулан ирүүлсэн зөрчил бүртгэгдээгүй байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь багтаан хүлээн авч ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 5.5 | “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах ажиллах. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны А/01 дүгээр захирамжаар батлагдсан “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 75,5 хувьтай нэгтгэн, газрын даргад танилцуулав.<br>Мөн Нийслэлийн “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний холбогдох заалтын биелэлтийг хагас жилийн байдлаар нэгтгэж, 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 хувь |
| 5.6 | Хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлуудын хэрэгжиж эхлэхээс өмнөх нөхцөл байдал, хэрэгжилтийн явц, мөн дууссаны дараах үр дүнг олон нийтэд хүргэх, ашиглагч байгууллага, хэрэглэгчдийн сэтгэгдлийг албан ёсны цахим хуудсаараа дамжуулан түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд манай газраас хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний үр дүнг олон нийтэд хүргэх чиглэлээр нийт 73 мэдээ бэлтгэн, газрын вэб сайт (https://invest.ub.gov.mn/), фэйсбүүк (https://www.facebook.com/nkhog), твитер (https://x.com/NHOG ) цахим хуудсаар тус тус нийтлэв. Үүнээс:<br>✓ Бүтээн байгуулалтын хэрэгжиж буй явцын 37 мэдээ,<br>✓ Бүтээн байгуулалт хэрэгжиж дууссан тухай 27 мэдээ,<br>✓ Газрын дотоод үйл ажиллагааны чиглэлээр 9 мэдээ.<br>Бүтээн байгуулалтын ажил хэрэгжиж эхлэхээс өмнөх 14 ажлын зургийг авч баримтжуулав. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн газрын нэгдсэн дотоод мэдээллийн (www.investpro.ub.gov.mn) систем болон (ubinvest) аппликэйшны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, шаардлагатай тохиргоонуудыг тухай бүр хийж, шинээр 2 инженер, мэргэжилтэнд эрх нээж, 7 инженерийн нууц үг сэргээв. Тус системийн эрх шилжих цэсэд **3** байгууллагын мэдээлэл нэмэв. Бусийн инженер хоорондын 34 ажлыг тухай бүр шилжүүлэв. | |
| 5.7 | Газрын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, хагас, бүтэн жилээр үр дүнг тайлагнах, хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газраас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд 18 гүйцэтгэгч хамрагдаж, 2026 оны 05 дугаар сарын 29-ний байдлаар үр дүнг нэгтгэж, Захиргааны хэлтсийн даргад танилцуулав.<br>Судалгаанд оролцогчдын 16 буюу 89 хувь нь сайн, маш сайн, 2 буюу 11 хувь нь дунд гэж үнэлж, дараах саналыг ирүүлсэн. Үүнд:<br>✓ Баримт бичиг батлагдах олон шат дамжлагыг багасгах,<br>✓ Гүйцэтгэлийн баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх,<br>✓ Хэлтэс нэгж, албан хаагчдын хоорондын ажлын уялдаа холбоог хангах,<br>✓ Баримт бичиг батлагдах процессийн зураглалыг нээлттэй ил тод болгох. | 100 хувь |
| 5.8 | Сул орон тооны зарыг газрын албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд нээлттэй зарлах | - | Тоо, хувь | - | 100% | Ажлын байрны сул орон тоог газрын албан ёсны вэб invest.ub.gov.mn сайтад нийт 4 ажлын байрны нээлттэй зарыг байршуулав. Үүнд:<br>✓ Барилга захилагчийн хяналтын хэлтсийн Авто замын хяналтын инженер-1<br>✓ Захиргааны хэлтсийн ажилтан Газрын даргын туслах-1<br>✓ Барилга захилагчийн хяналтын хэлтсийн Ус хангамж, ариутгах татуургын хяналтын инженер-1 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Захиргааны хэлтсийн Аян, олон нийтийн арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн-1<br>Газрын цахим хуудас http://invest.ub.gov.mn/-т хүний нөөцийн мэдээллийг тухай бүр шинэчлэв. | |
| 5.9 | Газрын үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг ойлгомжтой байдлаар газрын invest.ub.gov.mn вэб сайтад байршуулан ил тод байдлыг хангах | - | Тоо, хувь | - | 100% | Газрын үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг www.invest.ub.gov.mn вэб сайтын байгууллагын тухай, хууль эрх зүй, ил тод байдал, баримтын жагсаалт, төсөв санхүү зэрэг цэсэд нийт 106 (шинэчлэн) удаа байршуулж ил тод байдлыг хангаж ажиллав.<br>Мөн газрын www.invest.ub.gov.mn вэб сайтад бүтээн байгуулалтын мэдээ, мэдээллийг дараах байдлаар бэлтгэн нийтлэв. Үүнд<br>✓ крилл бичгээр 73<br>✓ англи хэлээр 11<br>✓ үндэсний бичгээр 22 | 100 хувь |
| 5.10 | Нийслэлийн Засаг дарга, Газрын даргаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр бүх шатны шүүх, хуулийн байгууллагад төлөөлөх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг тухай бүр танилцуулах | - | Тоо, хувь | 100% | 100% | Захиргааны хэргийн шүүхэд 3, Иргэний хэргийн шүүхийн шатанд 7, нийт 10 хэрэг маргаан байна.<br>*Захиргааны хэргийн шүүхийн шатанд хянагдаж байгаа 3 хэргийн хүрээнд:*<br>1.Нэхэмжлэгч "Түмэн-Алт" ХХК-ийн нэхэмжлэлтэй хариуцагч Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт холбогдох "Захиргааны хэргийн шүүх" хуралдаан хийгдэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Шүүхийн шийдвэр баталгаажсан бөгөөд нэхэмжлэгч одоогоор гомдол гаргаагүй байна. (Төсөл арга хэмжээ: Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1 хороо, Богд-Ар хороолол, түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй цэцэрлэгийн барилга, 200 ор)<br>2.Нэхэмжлэгч "Фужи-Алтай" ХХК-ийн нэхэмжлэлтэй "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-т холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн байна (төсөл, арга хэмжээ: Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хороо, Сургуулийн барилга, 640 суудал барилга угсралтын ажил)<br>3.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 128/ШШ2025/0139 дугаартай шийдвэрийг дахин хянуулах тухай “Хера пропертийз” ХХК-ийн гаргасан хүсэлтийг шүүх хүлээн авсан байна. (Сонгинохайрхан дүүргийн 5,6 дугаар хороо, ханын материал орчмын гэр хорооллын цэвэр усны ф100-300мм 3216 м шугамын барилга угсралтын ажил)<br>*Иргэний хэргийн шүүхийн шатанд хянагдаж байгаа 7 хэргийн хүрээнд:*<br>Улсын дээд шүүхэд 1, Нийслэлийн Давж Заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа анхан шатны шүүхийн 2 шийдвэр, Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд хянагдаж байгаа 4 иргэний хэрэг байна.<br>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой 18 удаа шүүх хуралдаанд оролцсон байна. | |
| 5.11 | Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо (KPI)-г сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажил нь төрийн албаны шинэчлэл, цахимжуулалттай холбоо байдаг.<br>Газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний тогтолцоог сайжруулах, KPI (гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт) нэвтрүүлэх ажлыг стратегийн зорилго тодорхойлох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал сонгох, автоматжуулах гэсэн 3 үндсэн үе шаттай нэвтрүүлэх ажлыг судалж байна. | 90 хувь |
| 5.12 | Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болдог захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Тус газар нь Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд гэрээний үндсэн дээр хяналт тавьж ажилладаг байгууллага юм. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Судалгааны баримт бичгийн стандартчилал батлах тухай" А/85 дугаар тушаалыг хэрэгжүүлэн газрын чиг үүргийн хүрээнд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг "Баримт бичиг-Статистикийн мэдээллийн маягтын" дагуу гарган, ажиллаж байна. | |
| 5.13 | Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015 стандарт, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандартыг газрын үйл ажиллагаанд тасралтгүй сайжруулалт хийж, баталгаажуулалтын гэрчилгээг сунгах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 84,9% | 100% | Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015 стандарт, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандартыг 2024 оноос эхлэн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна.<br>Тус стандартын шалгуур үзүүлэлтийг хангаж, 2025 оны баталгаажуулалтын гэрчилгээг амжилттай сунгуулсан.<br>2026 оны баталгаажуулалтын гэрчилгээний хугацааг сунгах ажлын хүрээнд магадлах аудитын бэлтгэлийг ханган ажиллаж байна. | 88.2 хувь |
| 5.14 | Байгууллагын дотоод болон гадаад (сонирхогч талууд) хэлэлцүүлэг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх. | - | Хэлэлцүүлэгийн тоо, хувь | - | 100% | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын худалдааны танхимтай хамтран "Бизнес эрхлэгчдийг дэмжих" жилийн хүрээнд "Барилга, дэд бүтцийн салбарын бизнес эрхлэгчидтэй хийх уулзалт"-ыг газрын асуудал, цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, инженерийн дэд бүтцийн хангамж чиглэлээр 2026 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн хангарди ордны "А" байранд зохион байгуулсан.<br>Тус уулзалтад гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл мөн газрын дарга Б.Мөнхбат оролцож, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даалгаврын хэрэгжилтийг холбогдох газарт хүргүүлэв. | |
| Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | 98.2 хувь |
| **ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | | **99.5 хувь** |

*Төлөвлөгөөг хянасан:*
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ: ................................................. (Б.ПҮРЭВДАГВА) ..................................
*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:*
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА: ................................................. (Б.ГАНЗОРИГ) 2026.06.10
*(огноо)*